



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 36,433,500.00 (гучин зургаан сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 3 дахь дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2.Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3.“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаранд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001703

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 1-ны өдрийн
АБД дугаар тогтоолын хавсралт



**"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
дахин нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 497 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ шинэчлэн тогтоосон
1	Говь-Сүмбэр салбарын УАЗ-2206 маркийн суудлын автомашин, ГСА 57-23 улсын дугаартай, Арлын дугаар -70428079, Моторын дугаар-502746	2007/2007	57981	16,483,500.00	3,000,000.00	1,500,000.00
2	Мицубиши пажеро маркийн ДГО 00-95 улсын дугаартай, арлын дугаар v75w0200468	2001/2013	24568	19,950,000.00	2,500,000.00	1,500,000.00
				36,433,500.00	5,500,000.00	3,000,000.00
	Нийт дүн			36,433,500.00 (гучин зургаан сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун)	5,500,000 (таван сая таван зуун мянган)	3,000,000.00 (гурван сая)